



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2018/01/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.com

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885

Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.com

Аудитор: Н.Нямдаваа

Утас: 261740

Цахим хаяг: nyamdabaan@audit.gov.com

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Бэст фортуна Аудит ХХК

Утас: 324338

Цахим хаяг: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг

Утас: 89116465, 98056465

Цахим хаяг: oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:

Ахлах аудитор: Б.Нарангэрэл

Утас: 99839547

Цахим хаяг: bavaanarangerel@yahoo.com

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ОТГОНБААТАР ТАНАА

2018.03.14 № 06/653
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherag\Yawsan_Bichig\2018\03\14\SAAG3.Docx

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

070911


Үүрэг, хариуцлага

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1 Оршил

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн санхүүгийн програм хангамжийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийг хурдасгах, нүүрсний үлдэгдлийг хэмжиж баталгаажуулж байх, авлага нэмэгдүүлэхгүй байх, бэлэн мөнгөний хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах, газрын эрхийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-д заасны дагуу Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 29-нээс 2018 оны 3 дугаар сарын 08-ны хооронд хийхээр төлөвлөн "Бэст фортуна Аудит" ХХК-ийн аудитын Б.Нарангэрэл ахлагчтай баг, ажлын талбар дээрх аудитын явцын хяналтыг Захирал Ж.Оюунцэцэг хэрэгжүүлэв.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 2017 оны санхүүгийн тайлан болон баримтуудаа 2018 оны 01 дүгээр сарын 29-нд 1/41Б дугаартай албан бичгээр хүлээлгэн өгсөн.

“Бэст фортуна Аудит” ХХК-ийн аудитын баг асуудлын бүртгэлийг 2018 оны 03 дугаар сарын 06-нд, аудитын дуусгавар болсон тайлан, менежментийн захидлыг 03 дугаар сарын 14-нд Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн удирдлагад хүргүүлж байна

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн зорилго нь хэрэглэгчийн хэрэгцээт цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэвийн найдвартай хангах явдал юм.

Үндсэн үйл ажиллагааны хувьд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, цахилгаан импортлох, эрчим хүчний тоноглолд засвар туршилт хийх, цахилгаан эрчим хүч дулааны эрчим хүчний тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах зэрэг 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Зүүн бүс нутгийн 36 сум суурин газрын 24710 айл өрх, 3133 аж ахуйн нэгж, байгууллага, 13 уул уурхай, газрын тос олборлолтын компаниудыг цахилгаанаар хангаж байна.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь Эрчим хүчний тухай, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Компанийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Татварын багц хууль, Шилэн дансны тухай, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, СТОУС, Сангийн сайдын 2000 оны 116 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг мөрдөн ажиллаж байна. Аудитаар Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-ыг мөрдөх зөвлөмж өгөв.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Компанийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 24 горим, сорил гүйцэтгэхээр төлөвлөснөөс аудитын явцад 6 горим сорилыг гүйцэтгэх шаардлагагүй гэж үзэв /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Veritech Accounting” онлайн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Дорнод бүсийн

эрчим хүчний систем ТӨХК-ийн дотоод хяналтыг төлөвлөлтийн шатанд 15 эрсдэл үр нөлөөгүй, “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт хангалттай байна.

2.6 Борлуулалтын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлт, түгээлтийн 2017 оны төлөвлөгөөг биелүүлж, зардлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингээр нийт орлого 38,351.5 сая, нийт зардал 35,809.9 сая төгрөгөөр тус тус батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоор 41,307.3 сая, техникийн үйлчилгээ, ЦДАШ, БУА-ын орлогоор 573.1 сая, хүүгийн орлогоор 264.9 сая, бусад орлогоор 99.6 сая төгрөг тус тус олж 37,784.2 сая төгрөгийн зардал гаргаж 4,463.9 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллаж 537.4 сая төгрөгийн татвар төлөхөөр тайлагнасан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэлийг оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 1 горим сорил хэрэгжүүлэв.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулав.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 30 эрсдэлтэй асуудал тодорхойлон, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 горим, сорил гүйцэтгэж доорх эрсдэлүүдийг олж тогтоон тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав. Үүнд:

Борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөлтийн тасалбар хугацаа, акурзаль сууриар бүртгэж авлага үүсгэсэн эсэх, зардлын хуваарилалт, нүүрсний үлдэгдэл баталгаажуулалт, цалингийн өглөг өссөн, санхүүгийн програмын ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл дунд, 28 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 11.0 % байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл дунд буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг асуулга хийх, тулган баталгаажуулах, түүвэрлэн шалгах аудитын горим сорил хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад доорхи материаллаг бус хэмжээтэй алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

2.9.1 Үндсэн хөрөнгө

2016 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүнгээр ТӨБЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 26-ны 654 дүгээр тогтоолоор 1,628.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, 87.0 сая төгрөгийн автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсний дагуу 2017 онд балансаас хассан байна. Гэвч үндсэн хөрөнгийг цаг хугацааны байдлаас хамаарч устгах шийдвэр гараагүй, дуудлага худалдаа тайлангийн хугацаанд зохион байгуулагдаагүй байна. 2016 оны жилийн эцсийн тооллогын үр дүнгээр шийдвэрлэх асуудлыг хугацаа хоцроон шийдвэрлүүлснээс тайлант онд асуудлыг иж бүрэн шийдвэрлэх боломжгүй болсон байна. Балансаас хассан хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн акт, нотломж гараагүй байгаа нь өмч хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх нөхцөл үүсч болзошгүй. Уг тогтоолд үр дүнг 2018 оны 01 дүгээр улиралд багтаан танилцуулахыг даалгажээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийг актлах, данс бүртгэлээс хасуулах асуудлыг хугацаанд нь тавьж шийдвэрлүүлэн тайлант хугацаанд хэрэгжүүлж байх зөвлөмж өгсөн

2.9.2 Худалдан авах ажиллагаа

2017 онд батлагдсан хөрөнгө оруулалт, их засвар, Техник зохион байгуулалтын арга хэмжээний 300.0 сая төгрөгийн 1 ажлаас 11 нэр төрлийн сэлбэг нийлүүлэгдсний 96.5 сая төгрөгийн төлбөр хийгдэж, 3 нэр төрлийн сэлбэг хугацаандаа нийлүүлэгдээгүй тул төлбөр тооцоо хийгдээгүй байна. /"Восток энерго монтаж" ХХК-тай байгуулсан турбины сэлбэг материал нийлүүлэх ажил/, 2 ажил он дамжин хэрэгжсэн байна. Шууд болон харьцуулалтын аргаар байгуулсан худалдан авах ажиллагааны гэрээ, гэрээ дүгнэсэн акт, бусад холбогдох баримт материалууд иж бүрэн бус байгаагаас үр дүнг хянаж үзэхэд хүндрэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг 1. Захирал дараахь эрх, үүрэгтэй:....3 /үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Гэрээний хэрэгжих хугацааг урьдчилан тооцоолж биелэлтийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн

2.9.3 Бараа материал

2017 онд 514.2 мянган тонн нүүрс худалдан авч 503.9 мянган тонн нүүрс зарцуулсан байна. Үйлдвэрийн үндсэн түүхий эд болох нүүрсийг хүлээн авахдаа нийлүүлэгчийн жолооч, 2 талын пүүлэгч нар гарын үсэг зурж жинг баталгаажуулж байна. Санхүүгээс сард 1-2 удаа хяналт хийдэг гэж байгаа боловч нотлох баримт үйлдээгүй байгаа нь нүүрс хүлээн авах, зарцуулах ажиллагаанд дотоод хяналт сул байгааг харуулж байна. Жилийн эцэст 40.0 мянган тонн буюу 615.2 сая төгрөгийн үлдэгдэл нүүрсэнд маркшейдерийн хэмжилт хийгээгүй, тооллогын акт үйлдээгүй, тооцоо бодож үр дүнг тодорхойлоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх", "үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авч байгаа нүүрсний пүүлэлт, жингийн байдалд тавих хяналтыг сайжруулах, баримтжуулах, улирал бүрийн эцэст нүүрсний үлдэгдэлд маркшейдерийн хэмжилт хийж, тооллогын акт үйлдэж, үр дүнг шийдвэрлэж байх зөвлөмж өгсөн

2.9.4 Газар эзэмших эрх

Тус компани нь 44 газрын эзэмших эрхийн гэрчилгээтэй боловч зөвхөн 1 газрыг санхүүгийн тайланд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний 193 дугаар тогтоолын “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Газар эзэмших эрхийг холбогдох дээд шатны байгууллагын шийдвэр гаргуулж хууль, тогтоолын заалтуудын дагуу санхүүгийн тайланд тусгах зөвлөмж өгсөн

2.9.5 Санхүүгийн программ

Нягтлан бодох бүртгэлийг Veritech Accounting санхүүгийн онлайн програмаар боловсруулан хөтөлж байна. Санхүүгийн програмаас санхүүгийн зарим мэдээлэлийг авах ажиллагаа шуурхай биш, програмын нэвтрүүлэлт, хөгжүүлэлт удаашралтай, мэдээллийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй, гэрээнд мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгаагүй, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан дансны жагсаалтыг програмд шинэчлээгүй байна. Тус компани нь улсын онцгой объектын хувьд мэдээлэл аюулгүй, найдвартай ажиллагаагаар хангагдсан байх ёстой

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг хууль, заавар, журамтай нийцүүлэх зөвлөмж өгсөн

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Петрочайна Дачин Тамсаг ХХК-нд нийлүүлэх цахилгааны үнийг 2015 оны 07 дугаар сарын 06-нд Эрчим хүчний зохицуулах хороо тогтоох үед ам.долларын ханш 1972.08 төгрөг байсан бол 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2427.13 төгрөг болж, төгрөгийн ханш 23.1 хувиар суларснаас 1.8 сая ам.доллар буюу 4.3 тэрбум төгрөгийн зөрүү гарч байна. Бүтээгдэхүүнээ ам.доллараар экспортлодог дээрх худалдан авагчийн хувьд төгрөгийн ханшийн зөрүүгээс ашиг хүртсэн гэж үзэхээр байна. Иймд цахилгааны тарифийг ам.долларт суурилсан байдлаар тогтоох саналыг Эрчим хүчний зохицуулах хороонд тавих нь зүйтэй

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

1. Актлагдсан 1,628.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн устгалт, 87.0 сая төгрөгийн автомашины нээлттэй дуудлагын худалдан борлуулалт,

2. 2017 оны жилийн эцэст Нийгмийн даатгалын байгууллагад 23.7 сая төгрөгийн шимтгэл илүү төлж үүсгэсэн авлагын барагдуулалт зэрэг асуудлуудыг дараагийн аудитаар авч үзнэ.

3. “Восток энерго монтаж” ХХК-тай байгуулсан турбины сэлбэг материал нийлүүлэх гэрээний хэрэгжилт

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нүүрсний үлдэгдэлд маркшейдерийн хэмжилт материаллаг бус зөрчил илэрсэн.

хийгээгүй, 615.2 сая төгрөгийн
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 3 зөвлөмж хэрэгжсэн байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2017 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 41,307.3 сая төгрөгөөр суурь үзүүлэлт болгон сонгож 1,5 хувиар буюу 619.6 сая төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин тооцох шаардлагагүй гэж үзэв. Борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөлтийн тасалбар болгох хугацааны хувьд өмнө нь уламжлалт эрсдэл байсан тул материаллаг байдлын сууриар сонгосон болно. /ТАБ-СТА-В1/

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

Бэст фортуна Аудит ХХК-ийн

Захирал



Ж.Оюунцэцэг

Ахлах аудитор



Б.Нарангэрэл

2018 оны 3 дугаар сарын 07